

БАЯНХОНГОР АЙМГИЙН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2024 оны 12 дугаар сарын 10

Номгон

№	Зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур	Биелэлт	Хувь
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	1.1.Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг а/bайгууллагын албан ёсны цахим хуудас, б/сошиал сүлгууд, в/дотоод сүлжээ, г/хэвлэл мэдээллийг хэрэгсэл, д/мэдээлэл сурталчилгаа самбар, лед дэлгэц, е/бусад (салбар байгууллагууд) хэлбэрээр сурталчилж, олон нийтэд хүргэх	-Баримтжуулсан байх -Үр дүнг тооцож, тайлагнасан байх. (түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо) -Харьяа газар, нэгжүүдийг хамруулсан байх.	Авлигатай тэмцэх газрын /www.iacs.mn/ вэб сайтад байршсан Авлигын эсрэг урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх 6 төрлийн зурагт хуудас, 24 төрлийн видео контентуудыг аймгийн сум, байгууллагуудын баaлhонгор.гов.тп цахим хуудас болон байгууллагын пэйж хуудсанд байршуулан 39 группэд түгээж, 15500 гаруй иргэний хандалт авч ажилласан.	100%
		1.2.Өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах	-2-оос доошгүй өдөрлөг, нөлөөллийн үйл ажиллагаа г.м соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байх; -Үр дүнг тооцож, нотломжийг хавсаргасан байх.	Авлигатай тэмцэх жилийн хүрээнд аймгийн хуулийн байгууллагуудтай хамтран Хуульчийн Про боно-өрөдлөг арга хэмжээг зохион байгуулан авлигын эсрэг үйл ажиллагааг 230 иргэнд үйл сурталчлан таниулж, эрх зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө, мэдээлэл өгч ганцаарчилсан зөвлөгөө үйлчилгээг 90 хүнд үзүүлж ажилласан. Мөн авлигын эсрэг сургалт сурталчилгаа зохион байгуулах эрх бүхий сурлагч багш нар хамтран төрийн үйлчилгээний хүртээмж, ил тод байдлыг сайжруулах, авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх хууль тогтоомжийн талаарх иргэд, төрийн албан хаагчдын эрх зүйн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлж оролцоог идэвхжүүлэхзорилгоор иргэдийн хамгийн их үйлчлүүлдэг төрийн байгууллагуудаас Улсын бүртгэлийн хэлтэс, Нийгмийн даатгалын газар, Нэгдсэн эмнэлэг, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрыг сонгон “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээг зохион байгуулсан. Өдөрлөгийн үеэр Улсын бүртгэлийн байгууллагаас 157, Нийгмийн даатгалын газраас 429, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газраас 80, Нэгдсэн эмнэлгээс 120 иргэн үйлчилгээ авсан байна. Мөн 4 байгууллагын 74 төрийн албан хаагчид авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх сургалт зохион байгуулж гарын авлага, календар тарааж ажилласан.	100%

1	2	3	4	5	6
				"Хүүхэд-Хууль" өртөөчилсөн сургалт, өдөрлөг зохион байгуулан Политехник коллеж болон Ерөнхий боловсролын найман сургуулийн 150 сурагчийг хамруулан шударга байхын ач тусыг ухуулан сурталчилсан. Тус өдөрлөг арга хэмжээний үр дүнд иргэдээс авсан саналыг нэгтгэн байгууллагын удирдлагуудад танилцуулан ажилласан бөгөөд зөвлөмж өгч хэрэгжилтэд хянал тавин ажилласан. Тус арга хэмжээг зохион байгуулсаны үр дүнд Иргэд өдөр тутам ихээр үйлчлүүлдэг төрийн 4 байгууллагад авлигаас ангид байж иргэдийн мэдэх эрхийг хэрэгжүүлэх хүрээнд нээлттэй хаалганы өдөрлөг арга хэмжээг зохион байгуулж тус байгууллагуудад зөвлөмж хүргүүлсний үр дүнд цахим хуудасны ил тод байдлаа 10-15 хувиар сайжруулсан.	
		1.3.Өөрийн байгууллагын эрх хэмжээ, үйл ажиллагаатай холбогдуулан эрхлэн гаргадаг ном гарын авлага, сэтгүүл, иргэдэд тараадаг хэвлэмэл материал, зэрэгт авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлуулах, шүтэл үлээхийг сурталчлан таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон авлигын мэдээлэл 110 дугаарыг оруулан сурталчлах;	-АТГ-ын авлигын мэдээлэл хүлээн авах дугаарыг төрөл бүрийн хэлбэрээр сурталчлан ажилласан байх; -Тайланд 110 дугаарыг сурталчилсан баримт бүрийн нотломжийг хавсаргасан байх.	Цахимд хэвшье" нээлттэй хаалганы өдөрлөг арга хэмжээг зохион байгуулан "Авлигын эсрэг хамтдаа нэгдье" уриа бүхий авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулсан 435 ширхэг гарын авлагыг иргэд төрийн албан хаагчдад түгээсэн. Мөн 110 дугаарыг сурталчилсан хаалганы наалт 75 байгууллагын 425 хаалганд нааж сурталчилсан. Иргэд олон нийтэд авлигын хууль тогтоомж, бодлого үйл ажиллагааг сурталчилан таниулах зорилгоор тарааж байгаа гарын авлагад аливаа шударга бус үйлдэл, үйл ажиллагааны талаарх үнэн бодитой мэдээллийг Авлигатай тэмцэх газрын 110 дугаарын утсанд өгөх талаар тогтмол сурталчлан ажиллаж байна. Авлигыг мэдээлэх 110 дугаарыг сурталчилсан 16 төрлийн гарын авлагыг 2400 гаруй иргэдэд тараасан. Мөн Шударга ёс хөгжил дэвшилд мэдээллийн самбарыг 13 байгууллага байршуулж авлигын эсрэг мэдээ мэдээллийг сурталчлан ажилласан.	100%
		1.4.Өөрсдийн байгууллагын үйл ажиллагаанд авлигад өртөж болзошгүй чиглэлийг сонгон авлигын эрсдлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий 2-оос доошгүй видео контент	-Авлигын эрсдлээс ангид байхад чиглэсэн 2-оос доошгүй контент бүтээлгэж олон нийтэд түгээж ажилласан байх;	Авлигаас ангид байх чиглэлээр 18 видео шторк, ёс зүйтэй байх чиглэлээр 2, хүүхдийн шударга байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн 5 видео, 1 контент, нийтийн албан тушаалтанд тавих хориглолт хягаарлалт сэдвээр 5, зөвшөөрөл олгохтой холбоотой 1, зөвлөн туслах үйлчилгээтэй холбоотой 1, төрийн байгууллагуудын албан ёсны үйл ажиллагаатай	100%

1	2	3	4	5	6
	бүтээж, олон нийтэд хүргэсэн байх	-Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм, youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх;	холбоотой 10 нийт видео шторк нийт 43 видео шторк бүтээж нийтэд түгээж ажилласан.		
Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийн бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх	2.1."Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх;	-Журмыг нийт албан хаагчдад танилцуулах нөлөөллийн ажлыг 2-оос доошгүй удаа зохион байгуулсан байх;	Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 109 дүгээр тогтоолын 2 дугаар зүйлийн 2.1.4 дэх заалтад зааснаар төрийн байгууллагын хүлээх нийтлэг үүргийн хэрэгжилтэд үнэлгээ хийлгэх хүрээнд Нийгмийн түншлэлийн сүлжээ ТББ-ыг сонгон Жөндөрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль төрийн 13, Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн 1 байгууллагыг үйл ажиллагаанд 2 сарын хугацаанд хяналт хийлгэх гэрээ байгуулан ажилласан. Тус ажлыг зохион байгуулснаар жөндөрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, зөвлөмж өгсөн ажлын тайлантай танилцан гэрээний хүрээнд холбогдох 6 байгууллагуудад сайжруулах шаардлагатай ажлын талаар зөвлөмж өгч ажилласан. Мөн "Цахим шилжилтийг эрчимжүүлэх" сэдвийн хүрээнд иргэд олон нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн цаашид хэрэгжүүлэх боломжтой төслийг шалгаруулах уралдаадыг 3 сая төгрөгийн болзолтойгоор 2 удаа зарласан боловч ТББ-аас төсөл ирүүлээгүй. Тус удирдамжийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон мэдээллийн самбарт байршуулан сурталчилсан.	100%	
2		2.2.Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх;	-Авлигаас урьдчилан сэргийлэх ажиллагаан дахь иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд	Аймгийн хэмжээнд нийт 324 ТББ байгаагаас 280 нь нийгэмд үйлчлэх ТББ байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр байгууллагуудаас "Хөгжлийн шийдэл" ТББ-тай хамтран төрийн байгууллагуудын авлигад өртөх эрсдэл бүхий албан хаагчдад Авлигын	100%

1	2	3	4	5	6
			Чиглэсэн 2-оос доошгүй нөлөөллийн ажил зохион байгуулсан байх;	эрсдлээс урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах ажлын хүрээнд "Авлига ба хүний эрх", "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль", "Нийтийн албан тушаалтанд тавих хориглолт хязгаарлалт" сэдвээр иргэдийн мэдэх эрхийг хангаж, төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх нийтийн эрх ашгийн төлөө шударга ёсыг эрхэмлэн, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, ил тод, шударга шийдвэр гаргахад нөлөөллийг бий болгох аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн байгууллагуудын төсөл хөтөлбөр хармуцан ажилладаг эрх бүхий 40 албан хаагчид сургалт зохион байгуулж, хэлэлцүүлэг өрнүүлэн эрх зүйн мэдлэг олголтыг нь нэмэгдүүлэн ажиллаласан.	100%
		2.3.Төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах;	-Төсөл арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх мэдээллийг иргэдэд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон өөр олон төрлийн суваг ашиглан сурталчлан таниулах ажлыг 2-оос доошгүй удаа зохион байгуулсан байх;	Орон нутгийн тусгай сангийн зарцуулалтын мэдээг Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны цахим хуудсанд сар бүрийн 8-ны дотор байршуулан мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллаж байна. Замын сангийн хөрөнгө оруулалтын 2024 оны төлөвлөгөө, гүйцэтгэлийг шилэн дансанд нээлттэй байршуулсан. Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан дүгнэлт өгсөн 82, түвэрт хамрагдсан 148, нийт 230 байгууллагын төсвийн захирагч, нягтлан бодогч, холбогдох ажилтнуудад нөлөөллийн мэдүүлгийг танилцуулан баталгаажуулж, FAS системд байршуулсан. Мөн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, худалдан авах ажиллагаа, төсөв хөрөнгөтэй холбоотой мэдээлэл агуулсан 2 төрлийн сонинг 400 ширхгийг хэвлүүлэн иргэдэд тарааж ажилласан байна.	100%
		2.4.Байгууллагуудын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлж хэвших;	-Шинэ томилогдсон албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад бүрэн хамруулсан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.	Аймгийн хэмжээнд 2024.01.01-ээс хойш тухайн албан тушаалд шинээр томилогдсон 18 сумын 96, 14 агентлагийн 20 нийт 116 албан хаагчдад албан үүргээ гүйцэтгэхдээ иргэдийн хүсэлтэд анхааралтай хандаж, ил тод, хармуцлагатай, ёс зүйтэй, хүнд сурталгүй ажиллах талаар чиглэл өгч "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх нь", "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль" сэдвээр авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг	100%

1	2	3	4	5	6	
	Авлига, сонирхлын үүсгэх нөхцөлийг арилгуулах хэмжээ авах	ашиг зөрчил шалтгаан, арга	3.1. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр тухайн байгууллагаас цахимаар иргэд, олон нийтэд үзүүлж буй цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээг зохион байгуулах	-Цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр 2-оос доошгүй нөлөөллийн ажил зохион байгуулсан байх; -Иргэдэд цахим хэрэглээг таниулж үйлчилгээг түргэн шуурхай авах нөхцөл боломжийг бүрдүүлсэн байх; -Нотломжийг тайланд хавсаргасан байх;	олгох сургалтыг 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн 70440001 дугаарын утсаар 16 санал гомдол ирсэнийг хуулийн шийдвэрлэн хариу өгч ажилласан. Аймгийн албан ёсны www.bayanhonogov.gov.mn вэб сайтаар 4 иргэнээс санал хүсэлт ирсэнийг шийдвэрлэж хариу өгсөн. Харин info@bayanhonogov.gov.mn цахим шуудангийн хаягаар иргэдээс гомдол санал ирээгүй болно. Монгол Улсын Засгийн газрын 1111 төвд тус аймгийн төрийн байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой ирүүлсэн 103 гомдол, санал, 10 талархалыг хүлээн авч холбогдох байгууллагад дамжуулах хуулийн хугацаанд шийдвэрлүүлж хариуг албан бичгээр хуруулан ажилласан. Өнөөдрийн байдлаар шийдвэрлээгүй 11 гомдол хүлээгдэж байна.	
3				Төрөөс иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний тоо болон хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Орон нутагт ХҮРДАН цэгүүдийн тоог үе шаттай нэмэгдүүлж байна. Энэ онд Баянхонгор аймгийн 9 суманд тус цэгийг нээн иргэдэд төрийн үйлчилгээг хүргэж байна. Төрийн үйлчилгээг цахимжуулж эхэлснээс хойш 37 төрлийн тусгай зөвшөөрлийг цахимд шилжүүлсэн. Ингэснээр иргэдийн хөрөнгө мөнгө цаг хугацааг хэмнэж ажлыг хөнгөвчилж байгаа юм. Тус онд 18,643 иргэнд хурдан цэгээс үйлчилгээ үзүүлж ажилласан. Нийгмийн даатгалын хэлтэс иргэд, даатгуулагчид portal.ndaafgal.mn хаягаар нэвтрэн орж жирэмсэн амаржсаны, хөдөлмөрийн чадвар алдалтын, ажилгүйлийн тэтгэмж зэрэг 3 тэтгэмжийн хүсэлтийг цахимаар илгээх. Мөн сайн дурын даатгалын гэрээг цахимаар байгуулах нөхцөл бүрдүүлсэн. Энэ үйлчилгээ нь иргэдэд сэтгэл ханамжтай байна. Худалдан авах ажиллагааны газар нь сумдад 7,4 тэрбум төгрөгийн 40 төсөл арга хэмжээний эрхийг шилжүүлж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 13 нэр төрлийн 34,9 тэрбум, урсгал төсвөөр 2 нэр төрлийн 47,8 сая төгрөгийн, орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалттай 8.1 тэрбум	100%	

1	2	3	4	5	6
		3.2. Байгууллагын дотоод хяналтын механизмт сайжруулж, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлоос ангид байхад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх;	-Албан хаагчдын дунд авлигаа ангид байхад чиглэсэн нөлөөллийн 2-оос доошгүй үр дүнтэй ажил зохион байгуулсан байх; -Байгууллагын алба хаагчид авлигын гэмт хэрэгт холбогдоогүй байх;	төгрөгийн 37 төсөл арга хэмжээ, нийт 53 нэр төрлийн 43,4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг 100% цахим хэлбэрээр зохион байгуулж үр дүнг тухай бүр нийтлэсэн. Энэ онд аймгийн Прокурорын газраас төрийн албан хаагчидтай холбоотой 7 гомдол мэдээллийг Авлигатай тэмцэх газарт шилжүүлсэн. Аймгийн хэмжээн дэх төрийн албан хаагчдын авлигын эрсдлийн тандалт судалгаанд 343 иргэн хамрагдсан. Судалгаанд оролцогчдын 43.7 хувь нь 20-45 насны иргэд оролцсон бөгөөд ажил эрхлэлтийн байдлаар ангилбал төрийн албан хаагч 56,9 хувийг, хувийн хэвшлийнхэн 16,9 хувь хамрагдсан. Судалгааг дүгнэн үзэхэд авлига их байна гэсэн дүн гарсан. Иймд авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчлах ажлын хүрээнд нээлттэй хаалганы өдөрлөг арга хэмжээг 7 удаа зохион байгуулж, авлигын эсрэг хууль тогтоомжийг-сурталчлах төлөвлөгөөт сургалтыг 10 удаа, төлөвлөгөөт бус сургалтыг 10 удаа захиалгат сургалтыг 39 удаа 29 сэдвээр зохион байгуулж аймгийн хэмжээнд 13,500 төрийн албан хаагчийг хамруулан ажилласан. Мөн онцлог ажлын хувьд "Авлигын эсрэг-Гэрэл түгээе" аяныг зохион байгуулсны үр дүнд фейсбүүкийн нүүр зургаа 751 албан хаагч шинэчлэн хүүхдийн ертөнцийг хүндэлбэ агуулга бүхий видео 5 ширхэг, авлигын эсрэг уриалга бүхий видео 4 ширхэг, тухайн байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан агуулга бүхий видео 13 ширхгийг тус тус бүтээж олон нийтэд түгээн ажилласан. Энэ онд аймгийн хэмжээнд шинээр авлигын гэмт хэрэг 17 бүртгэгдсэн бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад ижил түвшинд байна. Цахим хуудасны ил тод байдал 100 хувьтай. Шударга байдлын 2023 оны үнэлгээ 75.2 хувь болж өмнөх оноос 6.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Тус онд аймгийн хэмжээнд төрийн албан хаагчаас улс төрд нөлөө бүхий 2, захиргааны албан хаагч 6, цагдаагийн байгууллагын 1, бусад 3 нийт 10 авлигын гэмт хэрэг үйлдсэн. Тус онд авлигын гэмт хэрэг мөрдөн шалгахтай холбоотойгоор 1,086,794 төгрөгийн хохирол нөхөн төлүүлсэн. Харин аймгийн	100%

1	2	3	4	5	6
		3.3. Тухайн байгууллага өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр шинээр санал, санаачилга гарган тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх;	-Авлигын талаарх хууль тогтоомжийг 500-аас доошгүй иргэд, олон нийтэд сурталчлан ажилласан байх; -Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгасан байх -Удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнуудыг нөлөөллийн арга хэмжээнд хамруулсан байх;	Засаг даргын тамгын газрын албан хаагчдаас авлигын гэмт хэрэгт холбогдсон албан хаагч байхгүй болно. Албан үүргээ гүйцэтгэхдээ авлигаас ангид байх баталгааг 134 удирдах, 350 гүйцэтгэх албан тушаалтнаар гаргуулж ажилласан.	
		3.4. Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэл, албан бичгийн хэрэгжилт үр дүнт тооцон хариу арга хэмжээ авч ажиллах;	-Өгсөн үүрэг даалгаврын дагуу үр дүнтэй ажил зохион байгуулж хариуг хүргүүлсэн байх; -Зөвлөмж, чиглэл, албан бичгийн хариуг хугацаанд нь өгсөн байх;	АТГ-аас 2024.02.15-ны өдрийн 44/22/41 дугаартай албан бичгийн хүрээнд сумдад 2024.06.07-ны өдрийн 4/864 албан бичиг хүргүүлж зохион байгуулсан ажлын мэдээллийг АТГ-т хүргүүлсэн. Мөн тус газраас 2024 оны 33 дугаар мөрдөгчийн мэдэгдэлд 06 дугаар сарын 21-ний 1а/454 албан бичгээр, 2024 оны 123 дугаар мөрдөгчийн мэдэгдэлд 09 дүгээр сарын 20-ны 1а/703 албан бичгээр 2024 оны 11 дүгээр сарын 13-ны 181 мөрдөгчийн мэдэгдлийн хариуг 1а/937 албан бичгээр хариуг хугацаанд нь хүргүүлэн ажилласан. Мөн Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн 2024 оны 10 дугаар	100%

1	2	3	4	5	6
				сарын 18-ны өдрийн 02/16732 зөвлөмж, 12 дугаар сарын хугацаатай хугацаагүй албан бичгүүдэд заасан хугацаанд нь хариуг албан бичгээр хүргүүлж ажилласан.	
		3.5.Төлөвлөгөөний хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулж, үр дүнг үнэн зөв тайлагнан хагас жилд /6 дугаар сарын 25/, жилийн эцэст /12 дугаар сарын 25-ны дотор/ хүргүүлэх	-Тайланг хугацааны дотор Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэст ирүүлэх	Аймгийн 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааг 3 зорилт 13 арга хэмжээ төлөвлөн 100 хувьтай хэрэгжүүлж биелэлтийг тайлан, нотломжийн хамт цахим системд баталгаажуулан ажилласан.	100%
	Хэрэгжилтийн хувь				100%

ХЯНАСАН:
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Д.САРАНГАРАВ



НЭГТГЭСЭН:
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН Ж.ЛХАМДУЛАМ